



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/91

Ховд

Автотээврийн хэрэгслийн техникийн
хяналтын үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.3, 17.1.1, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.3, 9.4.7 дахь заалт, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь заалт, Жолоочийн даатгалын тухай хуулийн 5.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, сумдын автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг зохион байгуулах ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, явуулын техникийн хяналтын үзлэг хийх ажлын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн хэмжээнд автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 28-ны өдөр хүртэл, бүх төрлийн тээврийн хэрэгслийн 2024 оны татвар, авто зам ашигласны төлбөр төвлөрүүлэлтийг 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдөр хүртэл зохион байгуулж, дүнг хагас бүтэн жилээр Засаг даргын зөвлөлд оруулж танилцуулахыг ажлын хэсгийн дарга, Засаг даргын орлогч (Х.Батболд)-д даалгасугай.

3. Үзлэгийн хуваарь, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж оролцох талаар авто тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан бичгээр урьдчилан мэдэгдэж, сурталчилж ажиллахыг аймгийн Автотээврийн төвийн дарга (А.Энхмөнх), Цагдаагийн газрын дарга (Г.Цоодол), Татварын хэлтсийн дарга (Х.Батцэцэг), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Сумдад үзлэг зохион байгуулах салбар ажлын хэсгийг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах салбар зөвлөл болон татварын улсын байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, багуудын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллахыг сумдын Засаг дарга нарт, техникийн хяналтын үзлэгийн хуваарьт хугацаанд

автотээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бэлтгэлийг хангуулж бэлэн байлгах, үзлэгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүний ажиллах байр, тээврийн хэрэгслийн зогсоол талбай бэлтгэх, цахилгаан эрчим хүчээр хангах, төрийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг бүрдүүлэн дэмжиж хамтран ажиллахыг сумдын салбар ажлын хэсэгт тус тус үүрэг болгоугай.

5. Автотээврийн хэрэгслийн явуулын техникийн хяналтын үзлэгийн үеэр мотоциклыг бүртгэлжүүлэх, улсын дугаар олгох, тээврийн хэрэгсэл эзэмшигчийн өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээг солих, ашиглах боломжгүй болсон тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах, Автотээврийн тухай болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Автотээврийн төвийн дарга (А.Энхмөнх)-д үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллээр тогтмол хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Засаг даргын орлогч (Х.Батболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  БОЛОРМАА

Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/91 дүгээр захирамжийн нэгдүгээр
хавсралт

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: Х.Батболд (Засаг даргын орлогч)
- Гишүүд:
- Г.Цоодол (Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа)
 - Д.Энхзоригт (Цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа)
 - А.Жамъянсүрэн (Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Автотээврийн хяналтын улсын ахлах байцаагч)
 - Х.Батцэцэг (Татварын хэлтсийн дарга)
 - Ц.Лхагважав (Ховд аймгийн Автотээврийн төвийн хяналтын улсын байцаагч, зөвлөх инженер)
 - П.Батбаяр (Ховд аймгийн Автотээврийн төвийн хяналтын улсын байцаагч)
 - Э.Төмөр-Очир (Ховд аймгийн Автотээврийн төвийн хяналтын улсын байцаагч)
 - Л.Шинэгэрэл (Ховд аймгийн Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн мэргэшсэн инженер)
 - Н.Ирэхзаяа (Ховд аймгийн Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн инженер)
 - Б.Нямдорж (Ховд аймгийн Автотээврийн төвийн бүртгэлийн мэргэжилтэн)
 - Г.Оюунчимэг (Ховд аймгийн Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн техникч)
- Сумдын Засаг дарга нар
- Сумдын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаа
- Сумдын Татварын улсын байцаагч нар
- Даатгалын байгууллага
- Нарийн бичгийн дарга: А.Энхмөнх (Ховд аймгийн Автотээврийн төвийн дарга)
- оОо-



ХОВД АЙМГИЙН СУМДЫН 2024 ОНЫ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Техникийн хяналтын үзлэгийн зорилго

1.1. Монгол Улсын Автотээврийн тухай хууль болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай, Жолоочийн даатгалын тухай хууль болон холбогдох дүрэм журам, стандартыг хангуулах, аймгийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн техникийн байдал, хэрэглээний стандартын үзүүлэлтийг хангуулах, автотээврийн хэрэгслээс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Техникийн хяналтын үзлэг хамтран зохион байгуулах байгууллага, хамрах хүрээ

2.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Автотээврийн төв, Цагдаагийн газар, Замын цагдаагийн тасаг, Татварын хэлтэс, Гэрээт даатгалын байгууллага, нийт сум, багийн Засаг дарга хамтран төлөвлөгөөт хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.

2.2. Аймгийн хэмжээний авто тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэд бүрэн хамрагдана.

Гурав. Техникийн хяналтын үзлэг зохион байгуулах үе шат, хийх ажил

3.1. Автотээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэд техникийн бүрэн байдлыг хангаж, үзлэгт бүрэн хамруулах.

3.2. Автотээврийн хэрэгслийн өмчлөгч нь АТБӨЯХ-ийн албан татвар, авто зам ашигласны төлбөр, агаарын бохирдлын хураамж төлөгдсөн, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг үндэслэн автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулна.

3.3. Засгийн газрын шийдвэрээр батлагдсан техникийн хяналтын үзлэг явуулах хугацаа, төлбөрийн жишгийг үйл ажиллагаандаа баримтална.

3.4. Техникийн хяналтын үзлэгийн үед автотээврийн хэрэгслийн марк, модель, улсын дугаар, арал, бүхээг, хөдөлгүүрийн дугаар, өнгө, төрөл, зориулалт, өмчлөгчийн хаяг зэрэг бүртгэлийн үзүүлэлтийг автотээврийн хэрэгслийн гэрчилгээтэй нь нэг бүрчлэн тулгах бөгөөд автотээврийн хэрэгсэлд зайлшгүй шаардагдах нэмэлт хэрэгслийг (галын хор, ослын зогсолтын тэмдэг, эмийн сан г.м.) шалгана.

3.5. Тусгай зориулалтын автотээврийн хэрэгслийн (автокран) ачаа өргөх төхөөрөмжийн техникийн байдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар шалгаж баталгаажуулсан дүгнэлтийг үндэслэн техникийн хяналтын үзлэгт хамруулна.

3.6. Нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийг зөвхөн техникийн хяналтын үзлэгийн суурин төвд техникийн хяналтын үзлэгт хамруулна.

3.7. Техникийн хяналтын үзлэгийн инженер нь хяналтын үзлэгт хамрагдсан автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нарт тухайн автотээврийн хэрэгслийн техникийн байдлын талаар мэргэжлийн зөвлөгөө, зааварчилгааг өгнө.

3.8. Стандартын шаардлага хангаагүй автотээврийн хэрэгсэлд болон автотээврийн хэрэгслийг үзлэгт хамруулахгүйгээр техникийн хяналтын үзлэгт тэнцүүлэн дүгнэлт гаргахыг хориглоно.

3.9. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан автотээврийн хэрэгслийн мэдээллийг автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон автотээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн цахим санд тухай бүрт нь оруулж, сүлжээгээр хүргүүлнэ.

3.10. Үзлэг зохион байгуулах сумдын салбар ажлын хэсгийг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл, татварын улсын байцаагч, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, багуудын Засаг дарга нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, үзлэгийн хуваарьт хугацаанд автотээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бэлтгэлийг хангуулж бэлэн байлгах.

3.11. Сумдын салбар ажлын хэсэг явуулын техникийн үзлэг хийх үеийн тээврийн хэрэгслийн зогсох талбай, зогсоолын зурвас татах, цахилгаан эрчим хүчээр хангах, томилолтоор ажиллах бүрэлдэхүүний ажиллах, амрах байр бэлтгэх, амралтын өдрөөр холбогдох төрийн байгууллага, албан хаагчдийг ажиллуулах, сумын Төрийн банкны салбарын үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулна.

3.12. Орон нутагт техникийн хяналтын үзлэг явуулах хуваарь, мэдээллийг хэвлэл, мэдээлийн бүх сувгийг ашиглан тогтмол сурталчилж, техникийн стандартын шаардлага хангахгүй тээврийн хэрэгслийн зөрчлийг арилгуулах

3.13. Техникийн хяналтын үзлэгт хугацаанд хамруулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд мэдэгдэл өгөх, шаардах хуудас, улсын байцаагчийн албан шаардлага өгч, хуулийн хариуцлага тооцож ажиллах. Мөн харъяа сумынхаа бүртгэлтэй тээврийн хэрэгслийн 75-аас доош хувийг үзлэгт оруулсан сумын Засаг даргатай хуулийн хариуцлага тооцож, давтан үзлэг зохион байгуулах зардлыг төлүүлэх арга хэмжээ авна.

3.14. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, АТБӨЯХ-ийн албан татварын төвлөрүүлэлтийг дүн мэдээг сум, баг бүрээр гаргаж, үнэлгээ өгч аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.

Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 28-ны өдрийн
А/91 дүгээр захирамжийн гуравдугаар
хавсралт



ХОВД АЙМГИЙН СУМДАД 2024 ОНЫ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
ҮВУУЛЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ХИЙХ АЖЛЫН ХУВААРЬ

Д/д	Сум, багийн нэр	Томилолтоор ажиллах бүрэлдэхүүн	Бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо	2023 оны ТХУ хамрагдсан тоо	Ажлын хоног	Хуваарьт хугацаа
1	2	3	4	5	6	7
1	Манхан сум	Техникийн хяналтын үзлэгийн инженер-2, Техникч-1, Бүртгэлийн мэргэжилтэн-1, Автотээврийн төвийн хяналтын улсын байцаагч-3	1062	312	3	04.25-04.27
2	Зэрэг сум		620	359	3	04.28-04.30
3	Дарви сум		615	273	2	05.01-05.02
4	Хөшөөт уурхай		-	1200	7	05.03-05.09
4	Цэцэг сум		740	363	2	05.10-05.11
5	Мөст сум		726	200	2	05.12-05.13
6	Баянзүрх (Баянхайрхан) баг		-	60	1	05.14
6	Алтай сум		691	359	3	05.15-05.17
7	Үенч сум		896	388	2	05.18-05.19
8	Булган сум		2541	2000	10	05.20-05.29
9	Мөнххайрхан сум		380	160	2	05.30-05.31
10	Чандмань сум		658	384	3	06.02-06.04
12	Дөргөн сум		675	224	3	06.05-06.07
13	Мянгад сум		934	371	3	06.08-06.10
14	Буянт сум		1425	350	4	06.11-06.14
15	Эрдэнэбүрэн сум		643	303	2	06.15-06.16
16	Ховд сум		1580	345	3	06.17-06.19
17	Дуут сум	450	207	2	06.20-06.21	
18	Хөшөөтийн уурхай	-	-	-	-	2024.03
19	Хөшөөтийн уурхай	-	-	-	-	2024.08
	Нийт дүн				57	

-oOo-